ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 22 өдөр Дугаар 2/11 Сэврэй сум

Сэврэй сум 2025 оныг " Өрх гэр бүлийг дэмжих жил" болгон зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сэврэй сум 2025 оныг " Өрх гэр бүлийг дэмжих жил" болгон зарласугай.

2. 2025 оныг "Өрх гэр бүлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан баг, байгууллага, аж ахуйн нэгж бүр жилийн ажлын төлөвлөгөөндөө тодорхой ажлуудыг тусган хэрэгжүүлж ажилласугай.

3. Жилийн ажлын хүрээнд зохион байгуулагдах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахыг аялал жуулчлалын баазуудад уриалсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд үүрэг болгосугай.

ДАРГА Ч.ОГТБИШ

99462407092